



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ӨМА-2026/014/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.25 № 350

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГУРВАНТЭС СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ц.СУМЪЯА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гурвантэс сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц хөрөнгөөс иргэдэд эмчилгээний дэмжлэгийг анхан шатны баримтгүй олгосон, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, хөрөнгө бүртгэлд тусгаагүй, хөтөлбөр, арга хэмжээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн, үр дүн тооцоогүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 21 дүгээр зүйлийн 21.2.2 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,155.6 сая төгрөгийн дунд сургуулийн барилгын их засварын ажил хийгдсэн байна.

4626050056

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвийн орлогыг 53,589.6 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 64,245.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх 44,067.2 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Гурвантэс сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний дагуу 3 бодлогын хүрээнд 11 чиглэл 135 арга хэмжээг хэрэгжүүлэн 89.4 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.СӨХБЯЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>13,971,986.2</b>	<b>29,054,484.4</b>
32	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	4а, 4б	427,669.9	-
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	427,669.9	497,215.3
34	Урьдчилгаа	7а, 7б,	28,909.4	3,547.1
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	-	-
36	Нөөцийн бараа	9а	-	5,427,327.9
37300	Урт хугацаат зээл		-	-
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	55,245,834.1	60,069,745.0
39200	Биет хөрөнгө		55,052,311.7	59,878,199.4
39300	Биет бус хөрөнгө	13	193,522.4	191,545.6
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>69,217,820.3</b>	<b>89,124,229.4</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		12,104,703.5	12,866,206.0
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	928,510.1	1,285,136.4
41300	Өглөг	17а, 17б	927,969.2	1,285,136.4
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	540.9	-
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		11,176,193.4	11,581,069.7
42100	Урт хугацаат үнэт цаас	19	-	-
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	11,176,193.4	11,581,069.7
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		57,113,116.8	76,258,023.3
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		57,113,116.8	76,258,023.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		6,186,916.7	5,153,807.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		-	1,033,109.7
51200	Хуримтлагдсан үр дүн		50,273,788.9	69,418,695.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		652,411.2	652,411.2
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>69,217,820.3</b>	<b>89,124,229.4</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>77,526,453.0</b>	<b>78,298,132.6</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>33,191,417.5</b>	<b>43,998,327.0</b>
110	Орлогын албан татвар	27,738,307.4	37,537,918.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	27,783,307.4	37,571,019.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(45,000.0)	(33,101.5)
113	Хөрөнгийн албан татвар	2,164,912.7	2,084,414.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,288,197.4	4,375,994.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	33,749,501.6	34,299,805.6
120	Нийтлэг татварын бус орлого		2,430,807.4
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	10,585,533.9	
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	7,199,274.9	

21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,199,274.9	11,699,511.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,199,274.9	11,699,511.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,367,063.6	1,827,054.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,034.2	225,243.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	775,097.6	886,125.8
2104	Хангамж, бараа материалын зардал	873,528.1	2,542,381.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,926.9	82,623.0
2107	Томилолт, зочны зардал	43,424.0	33,360.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,638,846.9	1,667,880.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,198,353.6	4,434,843.7
212	ТАТААС	45,040.0	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,186,372.1	44,211,530.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,095,766.0	22,387,091.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,563,415.5	3,242,184.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(5,563,415.5)	(3,242,184.2)
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	37,532,350.5	19,144,906.5

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	49,144,223.1	73,009,406.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	33,191,417.5	43,998,327.0
110	Орлогын албан татвар	27,738,307.4	37,537,918.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	27,783,307.4	37,537,918.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(45,000.0)	(33,101.5)
113	Хөрөнгийн албан татвар	2,164,912.7	2,084,414.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,288,197.4	4,375,994.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,288,197.4	1,635,201.2
1181	Газрын төлбөр	2,787,315.3	2,714,563.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	20,311.9	26,229.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,364,866.7	29,011,079.1
120	Нийтлэг татварын бус орлого	5,364,866.7	22,727,152.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,587,938.9	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,145,073.6	55,821,713.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,145,073.6	55,821,713.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,977,941.0	6,590,972.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,942,551.1	2,519,879.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	329,609.9	225,214.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	817,444.0	975,826.2
2104	Хангамж, бараа материалын зардал	586,511.7	854,292.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,899.4	75,935.9
2107	Томилолт, зочны зардал	43,424.0	33,360.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,587,270.1	1,744,335.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	533,230.9	162,128.1
212	ТАТААС	45,040.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,122,092.6	49,230,741.1

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,999,149.6	17,187,692.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,954,451.9	5,195,449.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,954,451.9	5,195,449.1
2200	Дотоод эх үүсвэрээр	9,954,451.9	5,195,449.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(9,954,451.9)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,044,697.7	11,992,243.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,943,424.2	9,988,121.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,988,121.8	21,980,365.7

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,599,732.2	19,599,732.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(18,965.8)	(18,965.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,580,766.3	19,580,766.3
9	Тайлант үеийн үр дүн	37,532,350.5	37,532,350.5
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>57,113,116.8</b>	<b>57,113,116.8</b>
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>57,113,116.8</b>	<b>57,113,116.8</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,113,116.8	57,113,116.8
19	Тайлант үеийн үр дүн	19,144,906.5	19,144,906.5
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	<b>76,258,023.3</b>	<b>76,258,023.3</b>

#### 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	112,268,121.9	121,814,035.7	9,545,913.8
11	3.1.01.1.1 Татварын орлого	45,378,777.5	43,998,327.0	(1,380,450.5)
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	40,229,598.5	37,537,918.4	(2,691,680.1)
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	40,262,700.0	37,571,019.9	(2,691,680.1)
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	33,845,000.0	30,207,549.5	(3,637,450.5)
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	60,000.0	53,602.2	(6,397.8)
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	230,000.0	149,285.5	(80,714.4)
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	27,700.0	34,400.8	6,700.8
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	6,100,000.0	7,126,181.9	1,026,181.9
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(33,101.5)	(33,101.5)	-
110101	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(33,101.5)	(33,101.5)	-
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	2,313,500.0	2,084,414.6	(229,085.4)

<b>113001</b>	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,300,000.0	2,063,692.8	(236,307.2)
<b>113002</b>	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	3,500.0	4,395.0	895.0)0
<b>113004</b>	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	10,000,000.0	16,326,800.0	6,326,800.0
<b>118</b>	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,835,679.0	4,375,993.9	1,540,314.9
<b>1180</b>	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	353,000.0	1,635,201.2	1,282,201.2
<b>118001</b>	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	20,000.0	19,414.3	585.7
<b>118006</b>	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	283,000.0	1,584,610.9	1,301,610.9
<b>118009</b>	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	50,000.0	31,176.0	18,824.0
<b>1181</b>	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	2,467,679.0	2,714,563.0	246,884.0
<b>118101</b>	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	2,467,679.0	2,714,563.0	246,884.0
<b>1182</b>	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	15,000.0	26,229.7	11,229.7
<b>118203</b>	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	15,000.0	26,229.7	11,229.7
<b>12</b>	3.1.01.1.2 Татварын бус орлого	66,889,344.4	77,815,708.7	10,926,364.3
<b>120</b>	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	8,515,797.1	20,474,867.7	11,959,070.6
<b>120003</b>	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	8,197,050.60	20,237,780.31	12,040,729.71
<b>120010</b>	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	313,800.0	237,087.4	76,712.6
<b>120006</b>	3.1.01.1.2.1.7 Газрын тосны орлого	4,946.5	-	4,946.5
<b>122</b>	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	53,580,774.6	52,548,068.3	1,032,706.3
<b>122005</b>	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	53,580,774.6	52,548,068.3	1,032,706.3
<b>123</b>	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4,792,772.7	4,792,772.7	-
<b>123002</b>	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,792,772.7	4,792,772.7	-
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>62,719,919.4</b>	<b>110,215,429.5</b>	<b>47,495,510.1</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>57,730,139.2</b>	<b>106,492,420.9</b>	<b>48,762,281.7</b>
<b>210</b>	<b>3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,738,336.50</b>	<b>4,736,745.79</b>	<b>2,001,590.71</b>
<b>2101</b>	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,834,668.60	1,643,367.06	191,301.54
<b>210101</b>	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	912,968.90	780,338.57	132,630.33
<b>210102</b>	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	754,852.40	727,967.83	26,884.57
<b>210103</b>	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	67,855.10	42,904.12	24,950.98
<b>210104</b>	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	41,829.00	27,998.70	13,830.30
<b>210105</b>	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	57,163.20	64,157.85	6,994.65
<b>2102</b>	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,334.00	202,548.12	26,785.88
<b>210201</b>	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	155,946.7	139,503.9	16,442.8
<b>210202</b>	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	18,346.6	16,332.9	2,013.7
<b>210203</b>	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	9,173.6	8,111.3	1,062.3
<b>210204</b>	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	9,173.6	7,545.0	1,628.6
<b>210205</b>	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	36,693.5	31,054.9	5,638.6
<b>2103</b>	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,145,214.7	879,620.5	265,594.2
<b>210301</b>	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	90,964.7	61,346.4	29,618.3
<b>210302</b>	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	997,259.8	785,883.6	211,376.2

210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	56,990.2	32,390.5	24,599.7
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	741,509.1	402,860.4	338,648.7
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	35,360.6	14,526.3	20,834.3
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	118,373.0	86,421.8	31,951.2
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,846.5	7,576.3	2,270.3
210405	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	538,755.7	269,377.9	269,377.8
210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,173.3	24,958.1	14,215.2
2105	3.1.01.2.1.1.5 Нормативд зардал	5,000.0	-	5,000.0
210503	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000.0	-	5,000.0
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	156,672.2	75,935.9	80,736.2
210601	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	9,498.1	345.0	9,153.1
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	147,174.1	75,590.9	71,583.1
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	71,219.6	32,340.0	38,879.6
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	71,219.6	32,340.0	38,879.6
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,174,868.1	1,475,080.9	699,787.1
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,164,868.1	1,468,524.9	696,343.2
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	10,000.0	6,556.0	3,443.9
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	379,850.2	24,992.8	354,857.4
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	360,600.2	17,110.3	343,489.9
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,250.0	7,882.5	11,367.5
212	3.1.01.2.1.3 ТАТААС	6,200.0	-	6,200.0
2122	3.1.01.2.1.3.2 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	6,200.0	-	6,200.0
212201	3.1.01.2.1.3.2.01 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	6,200.0	-	6,200.0
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,985,602.7	101,755,675.2	50,770,072.2
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	50,985,602.7	101,691,299.2	50,705,696.5
213101	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	50,985,602.7	49,143,230.8	(1,842,371.8)
213103	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-	52,548,068.3	52,548,068.3
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	85,627.1	64,376.0	21,251.1
213205	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,862.1	38,136.0	1,726.1
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,765.0	26,240.0	19,525.0
22	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,989,780.2</b>	<b>3,723,008.6</b>	<b>1,266,771.6</b>
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	4,989,780.2	3,723,008.6	1,266,771.6
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	49,548,202.5	11,598,606.1	37,949,596.4
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(49,548,202.5)	(11,598,606.1)	(37,949,596.4)
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(49,548,202.5)	(11,598,606.1)	(37,949,596.4)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,907,705.1	(8,907,705.1)
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,506,311.2	(20,506,311.2)
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	92	108	(16)

<b>61</b>	<b>6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>-</b>
<b>610001</b>	6.1.01 Төсвийн байгууллага	8	8	-
<b>62</b>	<b>6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>42</b>	<b>50</b>	<b>(8)</b>
<b>620001</b>	6.2.01 Удирдах ажилтан	10	10	-
<b>620002</b>	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	23	29	(6)
<b>620003</b>	6.2.03 Үйлчлэх ажилтан	8	6	2
<b>620004</b>	6.2.04 Гэрээт ажилтан	1	5	(4)
<b>65</b>	<b>6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>42</b>	<b>50</b>	<b>(8)</b>
<b>650001</b>	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	17	12	5
<b>650009</b>	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	25	(9)
<b>650010</b>	6.5.10 Гэрээт ажилтан	1	5	(4)
<b>650011</b>	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
<b>1</b>	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,437,588.8</b>
<b>12</b>	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,437,588.8</b>
<b>122</b>	<b>1.1.1.1.1.1 Тусламжийн орлого</b>	<b>1,437,588.8</b>
<b>1221</b>	<b>1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/</b>	<b>1,437,588.8</b>
<b>12213</b>	<b>1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,437,588.8</b>
<b>350013</b>	<b>1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө</b>	<b>1,421,114.2</b>
<b>350014</b>	<b>1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө</b>	<b>9,701.7</b>
<b>350015</b>	<b>1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого</b>	<b>6,772.8</b>
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,422,519.5</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>230,972.1</b>
<b>210</b>	<b>1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>222,907.2</b>
<b>2101</b>	<b>1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>182,877.8</b>
<b>210104</b>	<b>1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал</b>	<b>182,877.8</b>
<b>2102</b>	<b>1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,666.4</b>
<b>210201</b>	<b>1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал</b>	<b>15,547.1</b>
<b>210202</b>	<b>1.1.1.2.1.1.2.2 Тэтгэмжийн даатгал</b>	<b>1,828.8</b>
<b>210203</b>	<b>1.1.1.2.1.1.2.3 ҮОМШӨ-ний даатгал</b>	<b>1,029.8</b>
<b>210204</b>	<b>1.1.1.2.1.1.2.4 Ажилгүйдлийн даатгал</b>	<b>776.3</b>
<b>210205</b>	<b>1.1.1.2.1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал</b>	<b>3,484.3</b>
<b>2104</b>	<b>1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,916.8</b>
<b>210402</b>	<b>1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун</b>	<b>2,766.8</b>
<b>210403</b>	<b>1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр</b>	<b>150.0</b>
<b>2107</b>	<b>1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал</b>	<b>1,020.0</b>
<b>210702</b>	<b>1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт</b>	<b>1,020.0</b>
<b>2109</b>	<b>1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,426.2</b>
<b>210901</b>	<b>1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,426.2</b>
<b>213</b>	<b>1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,064.9</b>

2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	8,064.9
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,064.9
22	<b>1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,191,547.4</b>
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	1,191,547.4
223001	1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө	1,191,547.4
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	15,069.3
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(15,069.3)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(15,069.3)

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 82.6 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

**Залруулсан алдаа:**

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг нэгтгэсэн тодруулга тайлантай тулган шалгахад 59,872.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн,
- Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн дүнг тодруулгын худалдаж авсан хөрөнгийн бүртгэлтэй тулгахад 11,000.0 мянган төгрөгөөр зөрүүлж тайлагнасан,
- Байгаль хамгаалах нөхөн сэргэлтийн сангийн үлдэгдэл 11,745.0 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд нэмэлтийн дансанд бүртгэсэн нь УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

**3.2 Төлбөрийн акт**

Тайланд онд зохион байгуулсан уралдаан тэмцээний шагнал урамшууллаас 2,444.0 мянган төгрөгийн албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-д "урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр", 21 дүгээр зүйлийн 21.2.2-д "энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар" гэж заасантай нийцээгүй байна.

**3.2 Албан шаардлага**

1.Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс төрийн албан хаагчдын магистрын төлбөрт 11,588.0, баруун бүсийн бүсийн тэмцээний дэмжлэгт 10,000.0, хүүхдийн байгууллага хөдөлгөөн үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой арга хэмжээний зөвлөгөөнд 3,000.0, цолцонгуудын арга хэмжээ, тэмээ аяллын дэмжлэгт, төстийн номын үнэ зэрэгт 15,000.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.Соёл, спортыг дэмжих хөтөлбөрийн зардлаас уралдаан тэмцээн зохион байгуулахад 132,603.7 төгрөг, Гоёот багийн түүхэн ном хэвлүүлэхэд 11,000.0 төгрөг, салбарын манлайлагч нарыг алдаршуулахад 5,500.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.Төлөвлөлттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт :** Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Гурвантэс" хөтөлбөрийн хүрээнд 7 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлуулсан нь Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй хөтөлбөртэй уялдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т "Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах хоёр сарын дотор багтаан боловсруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрийн хүрээнд төсвийг төлөвлөж захиран зарцуулах

#### 2.Дотоод хяналттай холбоотой асуудал

**Илрүүлэлт 2.1:** Эмчилгээний дэмжлэгт 33 иргэнд 128,360.0 мянган төгрөг олгохдоо зөвхөн дэмжлэг хүссэн иргэний нэхэмжлэхээр олгосон байна.

Энэ Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д "Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараах шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамруулахгүй", 11.2.4-д "эрүүл мэндийн байгууллагад төлсөн эмчилгээний зардалд зориулж олгосон тусламж, дэмжлэг" гэж заасан заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан шууд бус орлого болох эрүүл мэндийн байгууллагад төлсөн эмчилгээний төлбөр төлсөн баримтыг үндэслэн олгож байх

**Илрүүлэлт 2.2:** "Орон нутгийн болон зорилтот бүлгийн иргэдэд олгох нөхөн олговортой нислэг" ажлын гэрээг Геосан ХХК-тай байгуулан 283,400.0 мянган төгрөг олгосон ч хөтөлбөрийн үр дүнг тооцоогүй хэрэгжсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хэрэгжүүлж байгаа хөтөлбөр арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангаж чанартай хэрэгжсэн эсэхэд дүн шинжилгээ хийх

**Илрүүлэлт 2.3:** Хөтөлбөрийн зардлаас 5,000.0 мянган төгрөгийг хил хамгаалах арга хэмжээнд, 15,000.0 мянган төгрөгийг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг", 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн сангийн төлбөр тооцооны хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах

#### 3.Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт 3.1** Хөтөлбөрөөс нийт 13,350.9 мянган төгрөг зарцуулахдаа е баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалттай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг татвар төлөгчийн борлуулалт хийсэн дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг үндэслэн гүйлгээ хийх

**Илрүүлэлт 3.1** Сумын цагдаагийн тасагт шаардлагатай байгаа 3 ширхэг цахим бугуйвчны төлбөрт 2,550.0 мянган төгрөг төлсөн боловч бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Холбогдох байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг нэгтгэсэн тодруулга тайлантай тулган шалгахад 59.9 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн	1	59,872.5	-	-	1	59,872.5	1	59,872.5	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн дүнг тодруулгын худалдаж авсан хөрөнгийн бүртгэлтэй тулгахад 11.0 сая төгрөгөөр зөрүүлж тайлагнасан	1	11,000.0	-	-	1	11,000.0	1	11,000.0	-	-	-	-
Байгаль хамгаалах нөхөн сэргэлтийн сангийн үлдэгдэл 11.7 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд нэмэлтийн дансанд бүртгэсэн	1	11,745.0	-	-	1	11,745.0	1	11,745.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>82,617.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>82,617.5</b>	<b>3</b>	<b>82,617.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл асуудал

/мянган төгрөгөөр/

Алдаа зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөтөлбөр арга хэмжээнээс уралдаан тэмцээний шагнал урамшууллаас 2.4 сая төгрөгийн албан татвар суутгаагүй	1	2,444.0	1	2,444.0								
Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс төрийн албан хаагчдын магистрын төлбөрт 11.6, баруун бүсийн бүсийн тэмцээний дэмжлэгт	1	39,588.0			1	39,588.0						

10.0, хүүхдийн байгууллага хөдөлгөөн үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой арга хэмжээний зөвлөгөөнд 3.0, цолцонгуудын арга хэмжээ, тэмээ аяллын дэмжлэгт, тестийн номын үнэ зэрэгт 15.0 мянган төгрөг зарцуулсан												
Соёл, спортыг дэмжих хөтөлбөрийн зардлаас уралдаан тэмцээн зохион байгуулахад 132.6 төгрөг, Гоёот багийн түүхэн ном хэвлүүлэхэд 11.0 төгрөг, салбарын манлайлагч нарыг алдаршуулахад 5.5 сая төгрөг зарцуулсан	1	149,103.7			1	149,103.7						
Эмчилгээний дэмжлэгт 33 иргэнд 128.4 мянган төгрөг олгохдоо зөвхөн дэмжлэг хүссэн иргэний нэхэмжлэхээр олгосон байна.	1	128,360.0					1	128,360.0				
Орон нутгийн болон зорилтот бүлгийн иргэдэд олгох нөхөн олговортой нислэг" ажлын гэрээг Геосан ХХК-тай байгуулан 283.4 сая төгрөг олгосон ч хөтөлбөрийн үр дүнг тооцоогүй хэрэгжсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.	1	283,400.0					1	283,400.0				
Хөтөлбөрийн зардлаас 5.0 сая төгрөгийг хил хамгаалах арга хэмжээнд, 15.0 сая төгрөгийг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд санхүүжүүлсэн	1	20,000.0					1	20,000.0				
Хөтөлбөрөөс нийт 13.3 сая төгрөг зарцуулахдаа е баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар гүйлгээ хийсэн байна.	1	13,350.9					1	13,350.9				
Сумын цагдаагийн тасагт шаардлагатай байгаа 3 ширхэг цахим бугуйвчны төлбөрт 2.5 сая төгрөг төлсөн боловч бүртгэлд тусгаагүй	1	2,550.0					1	2,550.0				
<b>ДҮН</b>	<b>8</b>	<b>638,796.6</b>	<b>1</b>	<b>2,444.0</b>	<b>2</b>	<b>188,691.7</b>	<b>5</b>	<b>447,660.9</b>				
<b>Төрийн хэмнэлтийн хуулиар</b>												
Өндөр настан иргэдийг дэмжих арга хэмжээний зардлаас 2,340.0 мянган төгрөгөөр биеийн тамирын хослол, футболк худалдан авсан	1	2340.0	1	2340.0								
<b>НИЙТ ДҮН</b>	<b>9</b>	<b>641,136.6</b>	<b>2</b>	<b>4,784.0</b>	<b>2</b>	<b>188,691.7</b>	<b>5</b>	<b>447,660.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

